



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 4/156

Номгон

Аймгийн цэвэр усны эх үүсвэрийн
гүний худаг гаргах ажил хөрөнгө
гаргах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, аймгийн Онцгой комиссын 2021 оны 57 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн цэвэр усны эх үүсвэрийн 3 дугаар гүний худаг үерийн усанд өртөж дахин ашиглах боломжгүйгээр эвдэрч, гэмтсэний улмаас цэвэр усны эх үүсвэрийн 1 дүгээр гүний худаг аймгийн төвийн иргэдийг ундны цэвэр усаар бүрэн хангах боломжгүй болж, цаашид ундны усны хомсдолд орох эрсдэл өндөр байгаа тул цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрт худаг гаргах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж, хууль дүрэм, журмын дагуу зохион байгуулахыг Чандмань-Баянхонгор ХК-ын захирал М.Мөнхбат үүрэг болгосугай.

2. Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг гаргах үйл ажиллагааны зардал болох 117,102,200 (Нэг зуун арван долоон сая зуун хоёр мянга хоёр зуун төгрөгийг) Орон нутгийн хөгжлийн сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т, 57,000,000 (Тавин долоон сая) төгрөгийг НҮБ-ын Хүүхдийн сан-БНСУлсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага(KOICA)-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ажлын хэсгийн дарга Д.Энхжаргал)-д тус тус зөвшөөрсүгэй.

601210055

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН